



2023 оны // -р сарын 00 -ны өдөр

БАТЛАВ.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д. ТӨМӨРБААТАР

Д. Томорбаатар

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

БАТЛАВ.
“АРЖ КАПИТАЛ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Б. ТУВШИНДАВАА

Арж капитал

ХХК

9011044011-0301



Улаанбаатар хот

Дугаар
2023-03-379

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.14 дэх заалт, Нийслэлийн Байгаль орчны газрын 2023/55 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн: Ус ашиглуулагчийг төлөөлж Сонгинохайрхан дүүргийн Засаг дарбын Тамгын газрын Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн дарбын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Нямхүү, Ус ашиглагчийг төлөөлж Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Улсын бүртгэлийн 9011044011 тоот гэрчилгээ, 2810301 регистрацийн дугаартай “Арж капитал” ХХК-ийн төслийн захирал С.Баярбилэг нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нөхөн тооцож, 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл нэг жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр . Гэрээний нөхцөл:

2.1. Ус ашиглах зориулалт:

Авто зам, замын байгууламжийг барих, засварлах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

2. 2 Ашиглах усны хэмжээ:

-Ундаргаар нь тооцож үзэхэд 4,5л/сек ундрагатай.

Үйлдвэрлэлийн газар нь хоногт 45 м³ ус ашигладаг

1 ажилтан хоногт 180 л ус хэрэглэнэ 195 ажилтан 240 хоногт *150л= 7020.0м³,

Бетон үйлдвэрлэхэд 452,238 м³ ус ашиглана.

Шингэн турхлэг хийхэд 104.07м³ ус ашиглана.

Үйлдвэрийн 0.8 га талбайд Зам талбайн тоос дараахад 1 удаагийн усалгаанд 16.0м³ гэж үзвэл 90 хоногт 1440.0 м³ **Нийт 9016,308м³** ус ашиглах тооцоо гарсан байна.

2.3. Усны чанар, найрлага:

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, магни бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг буюу зэргийн эрдэсжилттэй, бага хатуулагтай ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтууд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS:0900:2018”-ын шаардлага хангаж байна.

2.4. Усны эх үүсвэрийн:

Байршил: Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Баруун түруунд,

Солбицол: **47°56'43.60"N, 106°37'8.78"E**

Барилга байгууламж: Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар гаргасан 100 м гүн, өрмийн худгаас барилга байгууламж байхгүй.

Тоног төхөөрөмж нэр марк:

Худагт FROG маркын усны насосыг 85 м гүнд суурилуулсан.

2.5. Хаягдал усны хэмжээ, хаях цэгийн байршил: Бетон доторлогоотой

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: Жилд 256 кг.

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: Ахуйн бохир усыг бохирын цооногт



хуримтлуулж бохир ус зөөвөрлөх мэргэжлийн Зуслан сэrvэн цохио ХХК-тай гэрээ байгуулж, бохир усыг зөөвөрлүүлж, бохирын төвлөрсөн шугамд нийлүүлдэг.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөцийн бохирдлоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ: Байхгүй.

2.9. Усны тоолуурын: Загвар, нэр, дугаар: маркын усны насосыг суурилуулсан.036269 дугаарын гэрчилгээтэй, LXSG маркийн усны тоолуурыг 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдөр суурилуулсан.

Тоолуур баталгаажуулалтын гэрчилгээ олгосон байгууллага огноо: Стандартчилал, хэмжил зүйн газар, 2022 оны 10-р сарын 17-ны өдөр

Тоолуурын заалт: 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 2023/55 дугаартай ус ашиглуулах дүгнэлтэнд заасан тоолуурын заалт **004682м³**.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ: 2022 оны усны нөөц ашигласны төлбөрийг “Усны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай”, Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 302, “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай”, “Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 326, 327 дугаар тогтоолуудыг үндэслэн 2022 оны 12 дугаар сарын 25-ний дотор тоолуурын заалтаар тооцож /1м³ ус 99,12 төг, 1м³ ус 188.8 төг / төлнө.

2.10.1 Авто замын бетон бэхлэгээ хийж үйлдвэрлэж ашиглахад 9016,308м³ газрын доорх ус ашигласны төлбөрт нийтдээ **943586.15./**Есөн зуун дөчин гурван мянга таван зуун наян зургаан / төгрөгийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасны дагуу усны нөөцийн төлбөрийн орлогыг ус ашиглах дүгнэлтээр тогтоосон дүнгээр 2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор барагдуулж ажиллана.

Гурав. Талуудын эрх үүрэг.

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглуулах дүгнэлтээр тавьсан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийн хангаж ажиллана.

3.3 Талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан мөнгөн буюу мөнгөн бус хэлбэрээр шагнал, шан харамж, урамшуулал зэрэг гэрээнд тусгагдаагүй аливаа төлбөрийг харилцан төлөөгүй болно.

3.4.Ус ашиглуулагч нь энэхүү гэрээнд заасан арга хэмжээг зохион байгуулахдаа ус ашиглагч талын удирдлагын баг болон ажилтан холбогдох албан тушаалтанд мэдэгдэхгүйгээр хувьд нь хөнгөлөлттэй ажил үйлчилгээ амлах, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг хориглоно.

3.5.Хэрэв үүнээс үүдэн талууд болон гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

7.4. Ус ашиглагч нь ус ашиглуулагч талын удирдлагын баг болон ажилтнаас энэхүү гэрээтэй холбогдуулан хөнгөлөлттэй худалдаа, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг шаардсан тохиолдолд үүнийг ус ашиглагч талын эрх бүхий албан тушаалтанд мэдээлэх үүрэгтэй.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаархи дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд жил бүрийн ус ашиглуулах дүгнэт, зөвшөөрөл, гэрээг тухай оны эхний улиралд багтаан байгуулна.
- 4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж тэмдэглэл үйлдэнэ.
- 4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.
- 4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.
- 4.5. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

Ж.Нямхүү


Байгаль орчин, ногоон байгууламж
хариуцсан мэргэжилтэн

С.Сүхцоож

СХД-ийн 27 дугаар хороо
3 давхар 319 тоот
Харилцах утас: 70173213
94007896


Ус ашиглагчийг төлөөлж:

“Арж капитал ” ХХК-ийн
Төслийн захирал



С.Баярбилэг

Байгаль орчны мэргэжилтэн



Ж.Солонго

Хаяг: Улаанбаатар хот ЧД 5 хороо Эм
Плаза 14 давхарт утас 77776868
99090442 88076882 Төслийн байршил
нь СХД-ийн 32 дугаар хороо Баруун
туруунд

